

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.020

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ, дүрэмт хувцас. Ерөнхий шаардлага	MNS 5851 : 2008
Symbol and uniform of special protected areas. General requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 17 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2008 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

- 1.1. Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулагдаж буй бүх ангиллын тусгай хамгаалалттай газарт энэхүү стандартыг мөрдөнө.
- 1.2. Энэ стандарт нь улсын тусгай хамгаалалттай газар нутагтай холбогдох тэмдэг тэмдэглэгээ, тэдгээрийн бичиглэлд тавих шаардлага болон тэмдэгшүүлэхэд хэрэглэх хилийн цэсийн тоот багана болон мэдээллийн самбарыг хийхэд мөрдөх техникийн шаардлага болон тэдгээрийг суурилуулах, тээвэрлэх шаардлагыг тогтооно.
- 1.3. Энэхүү стандартаар тухайн орчны газар зүйн байршлыг тогтоох, "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулиар тогтоосон хэм хэмжээг даган мөрдүүлэх үүрэг бүхий албан тушаалтан, хяналт шалгалтын байгууллагууд, нийт иргэдэд хамаарна.

2. Норматив ишлэл

Энэхүү стандартад иш татаж хэрэглэсэн доорхи баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг хэрэглэнэ.

- MNS-0391 : 1994, Шилмүүст зүсмэл. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 1228 : 1987, Хүнд бетон. Техникийн шаардлага;
- MNS4597 : 1998, Замын тэмдгүүд. Техникийн ерөнхий шаардлага.

3. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ ба бичиглэлд тавих шаардлага

- 3.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараах байдлаар товчлон бичнэ. Үүнд:
- a) Улсын тусгай хамгаалалттай газар нутаг – УТХГН
 - b) Дархан цаазат газар – ДЦГ
 - c) Байгалийн цогцолборт газар – БЦГ
 - d) Байгалийн нөөц газар – БНГ
 - e) Дурсгалт газар – ДГ
 - f) Орон нутгийн тусгай хамгаалалттай газар – ОНТХГ.
- 3.1. **Зөвшөөрөх тэмдэг** нь шар өнгийн дэвсгэр бүхий Т-1, Т-2, Т-3, Т-4 тэмдгүүд хамаарах ба зах хэсэг нь цэнхэр өнгийн 40 мм-ийн хүрээтэй, 400 мм x 400 мм хэмжээтэй тэгш дөрвөлжин биет байна. (G хавсралт)
- 3.2. **Хориглох тэмдэг** нь шар өнгийн дэвсгэр бүхий Т-5, Т-6, Т-7, Т-8, Т-9, Т-10, Т-11, Т-12 тэмдгүүд хамаарах ба зах хэсэг нь улаан өнгийн 40 мм-ийн хүрээтэй, 400 мм хэмжээтэй дугуй биет байна. (H хавсралт)
- 3.3. **Анхааруулах тэмдэг** нь шар өнгийн дэвсгэр бүхий Т-13, Т-14 тэмдгүүд хамаарах ба зах хэсэг нь улаан өнгийн 40 мм-ийн хүрээтэй, 400 мм хэмжээтэй адил талт гурвалжин биет байна. (I хавсралт)
- 3.4. Зөвшөөрөх, хориглох, анхааруулах тэмдгүүдийг гадна орчинд байх зориулалтын үл зэврэх, нийлэг голтой металл хавтан суурь буюу хавтгай төмөр дээр дүрсүүдийг хэвлэсэн байх ба гадна талын хүрээг гэрэл ойлгогч бүхий хэвлэлийн технологиор хийсэн байна.
- 3.5. Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд тэмдэг, тэмдэглэгээг байрлуулахдаа салхи шуурганд гэмтэхээс хамгаалах зорилгоор хавтгай гөлгөр гадаргуу бүхий банз, төмөр хүрээн дээр бэхэлж газраас дээш 1,6 м-ээс багагүй өндөртэй шонд бэхэлнэ.
- 3.6. Тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан байгууллага нь тэмдгүүдийг бэхлэх шонг сонгохдоо төмөр, бетон болон байгалийн ургаа модыг ашиглаж болох бөгөөд хөдөлгөөний эрчим ихтэй, онцлог газруудад байршуулна.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн багана ба мэдээллийн самбарт тавих шаардлага

- 4.1.1.** Улсын тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийн баганыг шилмүүст дүнзээр буюу төмөр бетон цутгамал хийцээр "Төмөр бетон MNS 1228:87" стандартын шаардлагын дагуу хийнэ (1-р зураг).
- 4.1.2.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэгшүүлэлтийн ажлыг гүйцэтгэхдээ "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуульд тусгагдсаны дагуу эрх бүхий байгууллагаар баталсан хилийн цэсийг мөрдлөг болгож тэмдэгт багана суурилуулах ажлыг гүйцэтгэнэ.
- 4.1.3.** Тусгай хамгаалалттай газарт нэвтрэх гол зангилаа замууд, байгалийн баялаг, илэрц бүхий газар, хүн амын төвлөрөл, хөдөлгөөний эрчим ихтэй газруудад хилийн цэсийн тоот багана ба мэдээллийн самбарыг байршуулна.
- 4.1.4.** Хилийн цэсийн тоот багана, түүний овор хэмжээ, загвар нь 1-р зурагт заасан шаардлагыг хангасан байна.
- 4.1.5.** Хилийн цэсийн баганад суурилуулах металл хавтан буюу хавтгай төмрийн хэмжээ нь 2-р зурагт үзүүлсэн хэмжээтэй адил байна.
- 4.1.6.** Нийлэг металл хавтан буюу хавтгай төмөр суурин дээр гадна орчинд зориулагдсан хэвлэлийн аргаар бичвэрийг хийх ба 2-р зурагт үзүүлсэн тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг харуулсан өнгийн шугамыг тухайн өнгөөр нь будах буюу гадна орчинд байх зориулалттай гэрэл цацруулдаг байхаар хийсэн байвал зохино .
- 4.1.7.** Хэрэв хилийн цэсийн тоот баганыг төмөр бетоноор хийсэн тохиолдолд 2-р зурагт үзүүлсэн бичвэр бүхий хавтанг бетон багана дотор бэхлэгдэж цухуйсан 4 ширхэг боолтод суурилуулж, шаавь бүхий эргээр цагийн зүүний дагуу эргүүлж бэхэлнэ. Баганыг дүнзээр хийсэн тохиолдолд бичвэр бүхий хавтанг 0,3 мм-ээс доошгүй зузаантай зэвэрдэгүй нимгэн төмрөөр урт хоёр талыг нь хүрээлж, 50 мм-ийн урттай эрэг, боолтоор баганад бэхэлнэ.
- 4.1.8.** Бичвэр бүхий хавтгайг суурилуулах талбай нь тэгш гөлгөр гадаргуутай байна.
- 4.1.9.** 2-р зурагт үзүүлсэн хавтан дээр тухайн тусгай хамгаалалттай газрын нэрийг 20 мм бусад бичвэрийг 16 мм-ээс

багагүй өндөртэй бичих ба өнгийг зурагт үзүүлсэний дагуу өнгөөр будна.

- 4.1.10. Тусгай хамгаалалттай газар болохыг анхааруулсан 1 ба 3-р зурагт үзүүлсэн хэрчлээст тэмдэглэгээг энэхүү стандартын С хавсралт ба D хавсралтад заасан харгалзах өнгөөр будах буюу гэрэл ойлгогч нийлэг металл хавтан буюу төмөр суурьтай материалаар хийнэ.
- 4.1.11. Металл хавтан дээр ил гарч бэхлэгдсэн эрэг, боолтыг будгаар будаж зэврэлтээс хамгаална.
- 4.1.12. Мэдээллийн самбарт зочид, аялагчдад зориулсан үгтэй, ямар эрх зүйн актаар хэдэн онд хамгаалалтад авсан, ямар нэртэй газар болох уг хамгаалалттай газарт зөвшөөрөх хийгээд хориглох үйл ажиллагаануудыг бичсэн байна.
- 4.1.13. Хилийн цэсийн багана ба мэдээллийн самбарын бичвэр бүхий металл хавтгайн гэрэл цацруулагч наалтыг 3 жил тутам солино. Шаардлагатай тохиолдолд дээрх хугацааг үл харгалзан сольж болно.
- 4.1.14. Тусгай хамгаалалттай газарт нэвтрэх цэг, гол зангилаа замууд дээр "Мэдээллийн самбар"-ыг байрлуулах ба самбарын нэг талын хэмжээ нь 1 м × 2 м-ээс багагүй байх ба хоёр талдаа бичвэр бүхий хавтан байвал зохино.
- 4.1.15. Самбарын 2 талын тулгуур шонг хийхэд энэхүү стандартын хилийн цэсийн тэмдэгт багана хийх бүх заалтыг мөрдлөг болгоно.
- 4.1.16. Самбарын шонгийн металл хавтгайн бичвэрийн хамгийн том үсгээр бичигдсэн үсгийн өндөр 30 мм-ээс багагүй байвал зохино.
- 4.1.17. Мэдээллийн самбарын арыг "Шилмүүст зүсмэл MNS-0391:1994" стандартад заасан шаардлагыг хангах зүсмэл модон материалаар хийнэ.
- 4.1.18. Тусгай хамгаалттай газар, нутаг тэдгээрийн орчны бүсийн хилийн зааг болон бусад мэдээллийг зураг дээр буулгадаа E; K; L хавсралтад заасан харгалзах өнгө болон тэмдэглэгээг баримтлана.

2. Суурилуулалтад тавих шаардлага

- 4.2.1. Хилийн цэсийн багана, мэдээллийн самбар суурилуулах орон зай нь нүдэнд ил харагдах, хатуулаг, суурилаг хөрс

бүхий газар байх ба суурилуулахдаа байгалийн болзошгүй аюулаас сэргийлж байрлуулна.

- 4.2.2. Хилийн цэсийн багана ба мэдээллийн самбарыг газарт 0,5 м-ээс багагүй гүнд суулгах ба энэ нь газраас дээш 1,6 м-ээс багагүй өндөртэй байна.
 - 4.2.3. Баганыг суулгахын өмнө товлосон газрыг 0,5 × 0,5 метрээс багагүй хэмжээтэй тэг дөрвөлжин буюу дугуй хэлбэрээр 0,5 метр гүн ухаж, 1:4,5 харьцаатай цемент, хайрган зуурмаг хийж бэхжүүлнэ. Цемент хэрэглэх боломжгүй зайлшгүй тохиолдолд бутрамтгай бус чулуу, дайргаар чигжинэ.
 - 4.2.4. Ухсан нүхнээс гарсан сул шороо, чулууг суурилуулсан тэмдэгт баганаас холдуулж, цэвэрлэнэ.
 - 4.2.5. Хилийн цэсийн багана суурилуулах ажлын явц бүрд тэмдэгт багана тус бүрийн фото зургийг орчны газрыг оролцуулан авах ба байршил тодорхойлогчоор байрлалыг тодорхойлж, ажил бүрэн дууссаны дараа гүйцэтгэлийн тайланг бичиж тухайн хамгаалалтын захиргаанд хүлээлгэж өгнө.
 - 4.2.6. Хилийн цэсийн баганын байрлалын цэг ба фото зургийг тухайн хамгаалалтын захиргааны мэдээлэл, хяналтын санд хадгална.
 - 4.2.7. Мэдээллийн самбарыг 3-р зурагт зааснаар угсарсаны дараа энэхүү зургийн 4-т заасны дагуу татлага төмрийг сүвлэн 1 үзүүрийг эргээр нь цагийн дагуу чангалж газарт суурилуулахад бэлэн болгоно.
3. **Тээвэрлэлтэд тавих шаардлага**
- 4.3.1. Тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийн баганын бичвэр бүхий хавтангуудыг зурагдаж, гэмтэхээс хамгаалж задалж тээвэрлэвэл зохино.
 - 4.3.2 Мэдээллийн самбарыг задалж тээвэрлэх ба төмөр бетон эдлэхүүнүүд ба мэдээлэл бүхий хавтангуудыг зөөлөн эдээр тусгаарлаж тээвэрлэнэ.
4. **Угсралт, суурилуулалтын үед шаардагдах багаж хэрэгсэл**
- Газарзүйн байршил тодорхойлогч GPS, теодолит
 - Зургийн аппарат
 - Хүрз, жоотуу, лоом
 - Эрэг чангалах түлхүүр
 - Цемент

- Эрэг ба шургыг будах төмрийн хар будаг
- Будгийн багс
- Метр
- 500 г-ын жинтэй алх
- 50 мм-ийн шрупп, халив

4.5. Шаардагдах хөдөлмөр хамгаалалын хувцас

- Ажлын хувцас (ердийн зориулалт)
- Химийн бодисоос хамгаалах хулдаасан хормогч
- Хошуувч, резин бээлий
- Нүдний тунгалаг шил

5. Тусгай хамгаалалттай газар нутгийн билэгдлийн ялгах тэмдэг, хэвлэмэл хуудас, туганд тавих шаардлага

- 5.1.** Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа нь өөрсдийн албан хэргийн хэвлэмэл материал, сурталчилгаа, чимэглэл, эд хөрөнгө, мэдээллийн самбар, байгаль хамгаалагчдын ялгах тэмдэг зэрэгт оюуны өмчийн газраас баталсан "Цагаан шонхор" шувууны дүрс бүхий тусгай хамгаалалттай газар нутгийн билэгдлийн ялгах тэмдгийг хэрэглэнэ.
- 5.2.** Хамгаалалтын захиргаа өөрсдийн газар нутгийн онцлог, ховордсон биологийн төрөл зүйлийг харуулсан билэгдлийн ялгах тэмдэгтэй байна.
- 5.3.** Билэгдлийн ялгах тэмдгийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн, оюуны өмчийн газраар баталгаажуулсан байна.
- 5.4.** Хамгаалалтын захиргаа албан хэргийн хэвлэмэл хуудасны зүүн дээд талд тусгай хамгаалалттай газар нутгийн билэгдлийн ялгах тэмдэг, баруун дээд талд өөрийн захиргааны билэгдлийн ялгах тэмдгийг байрлуулж, дунд нь захиргааны нэрийг бичнэ. (А хавсралтад үзүүлэв)

6. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, тэдгээрийн мэдээлэл-сурталчилгааны туганд тавих шаардлага

- 6.1.** Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, мэдээлэл сурталчилгааны төвүүд өөрсдийн онцлогыг харуулсан билэгдэл бүхий тугтай байж болох ба тугны урт, өргөн нь 1 × 2 гэсэн харьцаатай 0,8 м × 1,6 м хүртэл хэмжээтэй байна.

6.2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн туг цэнхэр, Хамгаалалтын захиргааны туг улбар шар, мэдээллийн төвийн туг ногоон дэвсгэртэй байх ба өөрсдийн билэгдлийн ялгах тэмдгийг 0,5 м-ийн голчтой дугуй дотор урласан байна. (М хавсралт)

7. Төрийн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчдын дүрэмт хувцас, ялгах тэмдэг

7.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчид, мэргэжилтэн, ажилтнууд ялгах тэмдэг бүхий дүрэмт хувцастай байвал зохино.

7.2. Дүрэмт хувцасны загварыг В хавсралтад үзүүлэв.

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ХАРЪЯА

УТХГН-ийн
эмблем

Тухайн ХЗ-ны
эмблем

..... ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА

..... оны сар өдөр

№

.....

Байгууллагын хаяг:

Байгууллагын утас, факс,
Е-мэйл хаяг, шуудангийн хайрцаг






**В хавсралт
(норматив)**



*Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчид,
мэргэжилтэн, ажилтнуудын дүрэмт хувцас*

С хавсралт
(норматив)

**Тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг,
тэмдэглэгээ**

д/д	Тэмдэглэгээний төрөл, нэр	Тэмдэг, тэмдэглэгээний хэлбэр, өнгө, хэмжээс		Тайлбар
		Зураг, баримт бичиг дээр	Биет байдал, газар дээр	
0	1	2	3	4
1	Дархан цаазат газар		Хилийн цэсийн багана ба мэдээллийн самбарын шон дээр (1 ба 3-р зураг) тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн зэргийг харгалзах өнгөөр нь ташуу шугамаар тэмдэглэнэ.	Хилийн цэсийн багана ба мэдээллийг самбарын бичвэрийг товчлохгүйгээр бичих ба үсгийн хэмжээ нь энэ стандартад заасан зохиомжоор (4.1.12-р заалт ба 4-р зураг) гүйцэтгэнэ.
2	Байгалийн цогцолбор газар			
3	Байгалийн нөөц газар			
4	Дурсгалт газар			
5	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар			







D хавсралт
(норматив)

**Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн зааг,
тэдгээрийн дотоод бүсүүдийн тэмдэг, тэмдэглэгээ**

д/д	Тэмдэглэгээний төрөл, нэр	Тэмдэг, тэмдэглэгээний хэлбэр, өнгө, хэмжээс		Тайлбар
		Зураг, баримт бичиг дээр	Биет байдал, газар дээр	
0	1	2	3	4
1	Тусгай хамгаалалттай газруудын хил, зааг			Тусгай хамгаалалттай газар нутгийн бүсүүдийн заагт нэвтрэн орох зам дээр болон онцлог газруудад шонг байрлуулна. Ташуу шугамыг 1-р зурагтзүүлсний дагуу 30 мм өргөнтэй ташуу шугамаар тэмдэглэнэ.
2	Онгон ба онцгой бүс			
3	Хамгаалалтын ба аялал, жуулчлалын бүс			
4	Орчны бүс			

С хавсралт
(норматив)

Тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааг
зөвшөөрөх тэмдэг, тэмдэглэгээ

д/д	Тэмдэглэгээний төрөл, нэр	Тэмдэг, тэмдэглэгээний хэлбэр, өнгө, хэмжээс		Тайлбар
		Зураг, баримт бичиг дээр	Биет байдал, газар дээр	
0	1	2	3	4
1	Авто хөспийн зогсоол			Зөвшөөрөгдөх тэмдэг, тэмдэглэгээг тухайн үйл ажиллагаа эхлэх газраас тодорхой зайд юм уу газар дээр нь байрлуулна.
2	Отог хоноглуулах газар байрлуулах		T-1	
3	Рашаан, шавар, эрдсийг эмчилгээнд ашиглах		T-2	
4	Байгалийн дагалт баялаг ашиглах		T-3	
5	Зөвшөөрөгдсөн газар загас барих		T-4	

F хавсралт
(норматив)

Тусгай хамгаалалттай газар нутагт тухайн үйл ажиллагааг хориглох тэмдэг, тэмдэглэгээ


д/д	Тэмдэглэгээний төрөл, нэр	Тэмдэг, тэмдэглэгээний хэлбэр, өнгө, хэмжээс		Тайлбар
		Зураг, баримт бичиг дээр	Биет байдал, газар дээр	
0	1	2	3	4
1	Дуут дохиог гаргах		T-5	Хориглох тэмдэг, тэмдэглэгээг тухайн үйл ажиллагааг хориглох газраас тодорхой зайд эсвэл газар дээр нь байрлуулна.
2	Хөрс, ус бохирдуулах үйл ажиллагааг явуулах		T-6	
3	Барилга, байгууламж барих		T-7	
4	Зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж явах		T-8	
5	Зөвшөөрөлгүйгээр буу авч явах		T-9	

Үргэлжлэл


0	1	2	3	4
6	Газар хагалах, ухах, тэслэх, элс, хайрга, чулуу авах, ашигт малтмал олборлох		Т-10	
7	Ан амьтан агнах, барих, үргээх		Т-11	
8	Мод огтлох, бэлтгэх		Т-12	

G хавсралт
(норматив)


Зөвшөөрөх тэмдгүүд




Отог хоноглох газар байгуулах



Байгалийн дагалт баялаг ашиглах



Рашаан шавар эрдсийг эмчилгээнд ашиглах



Зөвшөөрөгдсөн газар загас барих

Н хавсралт
(норматив)

Хориглох тэмдгүүд



Дуут дохио гаргах



Барилга байгууламж барих



Хөрс, ус бохирдуулах үйл ажиллагаа
явуулах



Зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж
явах

I хавсралт
(норматив)

Хориглох тэмдгүүд



Зөвшөөрөлгүйгээр буу авч явах



Ан амьтан агнах, барих, үргээх



Газар хагалах, ухах, тэслэх, элс,
хайрга, чулуу авах, ашигт малтмал
хайх, олборлох



Мод огтлох, бэлтгэх

Ж хавсралт
(норматив)

Анхааруулах тэмдгүүд











Гал гаргахдаа болгоомжлох









Ан амьтантай

К хавсралт
(норматив)






**Тусгай хамгаалалттай газар нутагт анхааруулах, заах,
таних тэмдэг, тэмдэглэгээ**

д/д	Тэмдэглэгээний төрөл, нэр	Тэмдэг тэмдэглэгээний хэлбэр, өнгө, хэмжээс		Тайлбар
		Зураг, бичиг баримт дээр	Биет байдал газар дээр	
1	Явган, морин аялал зохион байгуулах			Зурагт зааснаар тэмдэглэж, очих газрыг зайн хамт бичнэ.
2	Араатан амьтантай			
3	Гал гаргахдаа болгоомжлох		T-14	
4	Түүх соёл, дурсгалын зүйлс		T-13	
5	Өвөлжөө			
6	Хаваржаа, намаржаа			
7	Зуслан			
8	Төв суурин газар			

9	Байгалийн үзэсгэлэнт газар			
10	Жуулчны бааз			
11	Амралт сувиллын газар			
12	Худаг			
13	Халуун рашаан			
14	Хүйтэн рашаан			


L хавсралт
(норматив)

**Мэдээлэл сурталчилгааны зориулалттай тэмдэг,
тэмдэглэгээ**

д/д	Тэмдэглэгээний төрөл, нэр	Тэмдэг, тэмдэглэгээний хэлбэр, өнгө, хэмжээс		Тайлбар
		Зураг, баримт бичиг дээр	Биет байдал, газар дээр	
0	1	2	3	4
1	Мэдээллийн самбар		3-ЗУРАГ	Үсгийн хэмжээ нь энэ стандартад заасан хэмжээг баримтлана. Самбарын загвар нь 3-р зурагт заасан үзүүлэлтийг хангасан байна.
2	Байг			0,6 м × 0,6 м хэмжээний ногоон өнгийн дарцаг нь байгаль хамгаалагчдын байнгын оршин суух газарт байна. Дарцагны ишний урт нь 2,0 метр байна.
3	Рашаан, шавар, эрдсийг эмчилгээнд ашиглах		МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВ	ийн байршлыг олон нийтэд ойр байхаар тооцож тогтооно.
4	Байгалийн дагалт баялаг ашиглах		ХЯНАЛТ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ	Цэгийн байрлалыг тогтоохдоо зөрчил олон гардаг газруудыг харгалзан үзэж тогтооно.

М хавсралт
(норматив)

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн туг




М 1:20

Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны туг



М 1:20

Н хавсралт
(норматив)



1-р зураг. Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын
хилийн цэсийн багана


О хавсралт
(норматив)

180




2-р зураг. Хилийн цэсийн баганад суурилуулах металл хавтан

Р хавсралт
(норматив)



3-р зураг. Мэдээллийн самбарын ерөнхий байдал (1 – төмөр бетон шон, 2 – бичээр бүхий металл хавтан, 3 – эрэг, 4 – татлага төмөр, 5 – мэдээлэл бүхий металл хавтан, 6 – самбарын арын зусмал модон материал)

О хавсралт
(норматив)



4-р зураг. Төмөр бетон шонгийн ерөнхий байдал (1 – эрээстэй төмөр татуурга орох нэгт нүх, 2 – Мэдээлэл бүхий металл хавтан ба самбарын зүсмэл модон материал углуургадаж орох ховил)

